



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭМХЭТГЭЛ - 2019

STATISTICAL YEARBOOK OF SELENGE PROVINCE

2020 он





СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙГЭМ  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

2019

Сүхбаатар сум



## ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ТЭМДЭГЛЭЛ .....	3
АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР .....	4
ТОВЧ АГУУЛГА.....	6
1. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР .....	20
2. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	21
2.1 ХҮН АМ .....	21
2.2 ЭРҮҮЛ МЭНД.....	44
2.3 БОЛОВСРОЛ.....	53
2.4 ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....	78
2.5 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ.....	83
2.6 ГЭМТ ХЭРЭГ .....	84
2.7 ХИЛЭЭР ОРСОН, ГАРСАН ИРГЭД.....	87
3. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	89
3.1 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН.....	89
3.2 МӨНГӨ,БАНК.....	90
3.3 АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСӨВ, ТАТВАР .....	92
3.4 ГАДААД ХУДАЛДАА.....	94
3.5 ҮНЭ.....	95
4. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ.....	98
4.1 БИЗНЕС РЕГИСТР .....	98
4.2 ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	99
4.3 АЖ ҮЙЛДВЭР.....	117
4.4 БАРИЛГА.....	121
4.5 АВТО ТЭЭВЭР.....	121
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ.....	123
6. БУСАД.....	125



## Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэлгээ:

ГХ- Гэмт хэрэг

ХАА- Хөдөө аж ахуй

АҮ - Аж үйлдвэр

ЖДҮ- Жижиг дунд үйлдвэрлэл

СЭ - Сэлэнгэ

Ab – Алтанбулаг

Bb – Баруунбүрэн

Bg – Баянгол

Үер – Ерөө

Ja – Жавхлант

Zb – Зүүнбүрэн

Ma – Мандал

Or – Орхон

Ot – Орхонтуул

Sn – Сайхан

Sa – Сант

Sb – Сүхбаатар

Tu – Түшиг

Khu – Хушаат

Khr – Хүдэр

Tsn – Цагааннуур

Shr – Шаамар

II. Саруудыг ромбо тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

III. Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв

IV. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

X Бүтцийн өөрчлөлт

0.0 Маш бага тоо

+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй

\* Урьдчилсан

Догол мөр үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. "Төл" нь төлөвлөгөө, "Гүйц" нь гүйцэтгэл

VI. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100.0 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.



## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

**Хүн амын тоо.** Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.

**Суурин хүн ам.** Тухайн баг, хорооны нутаг дэвсгэрт 6 сараас дээш хугацаагаар оршин суугаа бүх хүнийг суурин хүн ам гэнэ. Мөн 6 сараас доош хугацаагаар түр эзгүй байгаа байнга оршин суудаг хүмүүсийг суурин хүн амын бүртгэлд оруулна.

**Өрх.** Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэж үзнэ.

**Хүйсийн харьцаа.** Хүйсийн харьцаа гэсэн үзүүлэлт нь 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоог илэрхийлдэг.

**Хүн ам зүйн ачаалал.** Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоог харуулдаг.

**Хүн амын нас-хүйсийн суварга.** Судалгаанд хүн амын нас, хүйсийн суваргаар нас, хүйсийн бүтцийг зураглан харуулдаг. Энэ нь зэрэгцүүлэхэд хялбар, хүйсний ялгавраар төв абцисс тэнхлэгээс хамгийн залуугаас эхлэн насны өсөх дарааллаар, доороос дээш суварган хэлбэртэй байна. Нас, хүйсний бүлэг бүр 100 хувьтай тэнцүү байна.

**Орон сууцны байшин.** Бүхэлдээ буюу ихэнх хэсэг нь сууцны зориулалтай, тоолох үед бүхлээрээ хүн амьдрахаас өөр зорилгоор ашиглагдаагүй байгаа суурин барилгын доторх сууцыг хэлнэ.

**Бие даасан тохилог сууц.** Бие даасан сууц (хаус) нь нэг өрх амьдрах зориулалтай, төвлөрсөн инженерийн шугам сүлжээний системд холбогдсон эсвэл инженерийн шугам сүлжээний системийн холболт болон оролт нь бие даасан, дулаан агааржуулалтын систем, усан хангамж, бохирын шугам, цахилгаан хангамж болон холбооны шугам сүлжээтэй, дотроо боловсон бие засах газартай байна.

**Төсөв:** Аймгийн төсвийн орлого зарлага нь төвлөрсөн төсвийн болон орон нутгийн төсвийн орлого, зарлагаас бүрдэнэ.

**Зээл:** Гэрээний дагуу олгосон мөнгөн хөрөнгийн төлбөрийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх үүсгэж байгаа санхүүгийн хөрөнгийг

**Ажилгүйчүүд:** Ажилгүйчүүдийн тоонд олон улсын стандарт ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

**Үнэ:** Аймгийн төвийн захад борлогдож байгаа болон хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулна.

**Хэрэглээний үнийн индекс:** Өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм.

**Гэмт хэрэг:** Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүй



алах хэргийг, хүүхэд гэр бүл нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулав.

**Малтай өрх.** Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

**Малчин өрх.** Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа өрх.

**Малчид.** Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болдог 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

**Төл мал.** Тухайн жилийн төлийг хэлнэ.

**Бэлэн хээлтэгч.** Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

**100 эхээс бойжуулсан төл.** Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж гаргах ба энэ нь 100 төл тутамд бойжсон төлийн тоог хэлнэ.

**Тариалангийн талбай талбай.** Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ.Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**Тариалсан талбай.** Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Хураасан талбай.** Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

**Аж үйлдвэр:** Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж, байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ юм.



## ТОВЧ АГУУЛГА

### Сэлэнгэ аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2019 оны жилийн эцсийн байдлаар)

#### 1. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР



##### 1.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж

Сэлэнгэ аймаг нь 17 сум, 57 багтай. Үүнээс Тосгоны статустай Дулаанхаан, Бугант, Номгон, Рашаант, Тунхэл, Хэрх гэсэн 6 багтай. Хамгийн олон хүн амтай сум нь Мандал 26 547, аймгийн төв Сүхбаатар сум 22 505, Сайхан сум 9 170 байна. Нутаг дэвсгэрийн хэмжээ 41152.6 км<sup>2</sup>, нэг хавтгай дөрвөлжин км квадрат талбайд 2.6 хүн ногддог. Хүн амын нягтрал хамгийн их нь Сүхбаатар сум 1 км<sup>2</sup>-д 502.8 хүн ногдож байна.

#### 2. НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ




##### 2.1 Хүн ам

2019 оны жилийн эцэст суурин хүн амын тоо 107 755 -д хүрсэн нь өмнөх оноос 1.4 хувиар буурч, 1990 оноос 21.2 хувиар, 2000 оноос 13.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хүн амын нас хүйсийн бүтцээр авч үзвэл нийт хүн амд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 50.8, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 49.2 байгаа бол 0-14 насны хүүхэд 29.8, 15-59 насны хүн 62.9, 60-аас дээш насны хүмүүс 7.4 хувийг эзэлж байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар манай аймагт бусад аймаг хотоос бүгд 2 777 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үеэс 158 (1.1%) хүнээр өссөн үзүүлэлттэй байна. Нийт шилжин ирэгсдийн 1 357 (48.9%) нь эрэгтэйчүүд, 1 420 (51.1%) нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэйчүүдийн тоо 61 (4.7%) хүнээр, эмэгтэйчүүдийн тоо 97 (7.3%) хүнээр тус тус өссөн байна.

Сэлэнгэ аймагт оршин суугаа хүн амын тоо



##### 2.2 Эрүүл мэнд

Сэлэнгэ аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагад их эмч 247, эм зүйч 32, тусгай мэргэжлийн 607 мэргэжилтэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 2019 онд 1 772 эх амаржиж, 1 780 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эх 67 (3.9%) -оор, амьд төрсөн хүүхэд 74 (4.3%) -оор, 2010 оноос амаржсан эх 124 (6.6%) -оор, амьд төрсөн хүүхэд 129 (6.8%) -оор, 2015 оноос амаржсан эх 173 (8.9%) -аар, амьд төрсөн хүүхэд 176 (9.0%) -аар тус тус буурчээ.




Төрөлтийг насны бүтцээр нь харахад 25-29 насны 508 (28.7%), 20-24 насны 411 (23.2%), 30-34 насны 455 (25.7%), 35-39 насны 263 (14.8%), 40-44 насны 40 (2.3%), 45-49 насны 2 (0.1%), 20 хүртэлх насны 93 (5.2%) эмэгтэй байна.

2019 онд 2 234 жирэмсэн эх шинээр хяналтад орсны 82.9 хувийг жирэмсний эхний 3 сарын дотор хяналтад авсан байна. 2019 онд шинээр хяналтад авсан жирэмсний 96.2 хувийг цусны шинжилгээнд хамруулснаас 42.6 хувьд нь сум, тосгодын эмнэлгүүдэд гемоглобины тестээр шинжилсэн ба шинжилгээнд орсон 2 148 жирэмсний 1.1 хувьд нь цус багадалт илэрчээ.

Нас барсан хүний тоо 2019 онд 502 болж, 2010 оноос 55 (9.9%)-аар, өнгөрсөн оны мөн үеэс 27 (5.2%)-оор буурсан байна. Нийт нас баралтын шалтгааны 10.8 хувь нь осол гэмтлийн, 25.7 хувь нь хорт хавдрын өвчний шалтгаантай байна. 0-1 хүртэлх хүүхдийн эндэгдэл 17, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1 (5.6%)-ээр буурсан бол, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 2 (66.7%)-оор өссөн байна.

Төрсөн эх, амьд төрсөн хүүхэд



Халдварт өвчнөөр өвчлөгчид 2019 онд 730 болж, өмнөх оны мөн үеэс 75 (9.4%)-аар, 2010 оноос 317 (30.3%)-оор, 2015 оноос 159 (17.9%)-өөр тус тус буурсан байна. Нийт халдварт өвчний 56.6 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 22.6 хувийг сүрьеэ, 20.8 хувийг бусад халдварт өвчин эзэлж байна.

2019 онд нийт 409 341 үзлэг хийсний 29.6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 24.1 хувь нь гэрийн идэвхтэй үзлэг, 28.5 хувь нь диспансерийн хяналтын үзлэг эзэлж, нийт 33 123 дуудлагад үйлчилсний 12.9 хувийг алсын дуудлагаар үйлчилж яаралтай тусламж үзүүлсэн байна.



### 2.3 Хүүхэд, гэр бүл, боловсрол, биеийн тамир спорт

Ерөнхий боловсролын сургуульд 2019- 2020 оны хичээлийн жилд 35 сургуульд 1 075 үндсэн багш ажиллаж байгаа ба үүнээс эмэгтэй үндсэн багш 889 байна. Үндсэн багш 2010 онд 965 байсан бол 2015 онд 1035 болжээ. Нийт 20 338 сурагч суралцаж байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 10 091 сурагчид сурч байна. Суралцагчид 2010 оноос 1 433(7.5%)-аар, 2015 оноос 1 925(10.4%)-аар тус тус өссөн байна. Энэ хичээлийн шинэ жилд 1 131 хүүхэд шинээр нэгдүгээр ангид элсэн орж, албан бус сургалтад нийт 312 сурагч суралцаж байна.



Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрт 10 346 хүүхэд хамрагдаж 896 052.3 мян.төг зарцуулжээ. Ерөнхий боловсролын сургуульд 1 772 нийт ажиллагсад ажиллаж байгаа бөгөөд эмэгтэй 1 403 ажиллагсад байна.

Аймгийн хэмжээнд 42 цэцэрлэгийн 278 бүлэгт 299 багш багшилж, 8 382 хүүхэд хүмүүжиж байна. 2010 онд 33 цэцэрлэг, 201 бүлэг, 180 багш, 6211 хүүхэд хүмүүжиж байсан бол 2015 онд 38 цэцэрлэг, 243 бүлэг, 248 багш, 7437 хүүхэд хүмүүжиж, 2015 онтой харьцуулахад цэцэрлэг 5(15.1%)-аар, бүлэг 42(20.8%)-оор, багш 68(37.7%)-аар, хүүхэд 1226(19.7%)-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлангийн хугацаанд биеийн тамир, спортын 171 секц дугуйлан хичээллэж, 3 190 хүн хамрагджээ. Мөн хугацаанд улс, тив, дэлхий, нэрэмжит тэмцээнээс 196 медаль авсан байна.

2019 оны байдлаар хүүхэд хамгааллын чиглэлээр хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 94 хүүхэд байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 42 (30.9%) хүүхдээр буурсан байна. Хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд 90 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 28 (23.7 %) хүүхдээр буурсан байна.

Гэр бүлийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд үзүүлсэн сургалт 9, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн иргэд 934 байна.

Хүүхдийн хөгжил оролцооны чиглэлээр багачуудын дунд хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх чиглэлээр зохиосон 5 удаагийн арга хэмжээнд 174 хүүхэд хамрагдсан байна. Улсын чанартай уралдаан тэмцээнээс 64 хүүхэд медаль авчээ.




## 2.4 Хөдөлмөр

2019 оны байдлаар бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 640 болсон нь 2010 онтой харьцуулахад 375 (33.5%) хүнээр, 2015 онтой харьцуулахад 158 (19.8%) хүнээр, 2018 онтой харьцуулахад 105 (14.1%) хүнээр тус тус буурсан байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 640 болсны 294 (45.9%) нь эмэгтэйчүүд байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 57.2 хувийг ерөнхий боловсролтой, 24.1 хувийг дээд боловсролтой, 14.1 хувийг мэргэжилтэй ажилчид, 3.8 хувийг тусгай дунд боловсролтой, 0.8 хувийг боловсролгүй хүмүүс эзлэх боллоо. Энэ сард бүртгэлтэй ажилгүйчүүдээс 89 хүн ажилд зуучлагдан орж, 64 хүн идэвхгүйн улмаас хасагдаж, 140 хүн шинээр бүртгэгдсэн байна. Шинээр 1 043 ажлын байр бий болж хөдөө аж ахуй, ан агнуур ой аж ахуй загас агнуур, уул уурхай, боловсруулах үйлдвэр, худалдаа гэр ахуйн засвар үйлчилгээ, боловсролын салбар тус тус 70.8 хувийг эзэлж байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролоор






## 2.5 Нийгмийн даатгал, халамж

2019 оны байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 16 991 тэтгэвэр авагчдад 70 822.9 сая төгрөгийг олгож, олгосон тэтгэврийн хэмжээ 2010 оноос 31 953.5 (45.1 %) сая төгрөгөөр, 2015 оноос 31 953.5 (45.1%) сая төгрөгөөр тус тус өссөн байна. 2018 онтой харьцуулахад тэтгэвэр авагчдын тоо 481 (2.9%) хүнээр өсч, олгосон тэтгэврийн хэмжээ 2 879.6 (4.2%) сая төгрөгөөр өссөн байна. Тэтгэмжийн даатгалын сангаас 7 642 хүнд 3 261.2 сая төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулга, өвчтөн сахисны тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин, даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 287 хүнд 1 165.1 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 568 хүнд 905.9 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгожээ.

Нийгмийн халамжийн сангаас 45 631 хүнд 14 627.8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг олгосон нь өмнөх оноос нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 684 (1.5%) хүнээр буурч, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 748.4 (5.4%) сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, сая.төг




## 2.6 Гэмт хэрэг




2019 оны байдлаар Цагдаагийн газрын мэдээгээр нийт 767 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 12 (1.5%)-оор буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 170 (22.2%) нь согтуугаар үйлдэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23 (9.1%)-аар буурсан байна.

Иргэн болон байгууллагад нийт 2 700.7 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үеэс 1 050.9 (1.6дахин) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлоос 1 122.2 сая төгрөгийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлт 41.6 хувьтай байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 237 (30.9%) нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 316 (41.2%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 101 (13.2%) нь байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, 39 (5.1%) нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 74 (9.6%) нь бусад төрлийн гэмт хэрэг эзэлж байна. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн 66 (20.9%) нь малын хулгай эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс 29 (4.7%)-өөр буурсан байна.


**Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр****2.7 Хилээр орсон, гарсан иргэд**

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Сүхбаатар боомтоор давхардсан тоогоор 666.8 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 83.0 (11.1%) мянган хүнээр буурсан байна. Нийт зорчигчдын 525.3 (78.8%) мянга нь Монгол иргэд, 141.5 (21.2%) мянга нь гадаад иргэд байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилээр нэвтэрсэн Монгол иргэдийн тоо 70.9 (11.9%) мянган хүнээр, гадаад иргэдийн тоо 12.1 (7.9%) мянган хүнээр буурсан үзүүлэлттэй байна.


Монгол-Оросын хилийг хялбарчилсан журмаар хил нэвтрэх эрхийн үнэмлэхээр 31 821 хүн зорчсон байна.

**Хилээр нэвтэрсэн зорчигч, мян.хүнээр****3. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ****3.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн**

Аймгийн 2019 оны дотоодын нийт бүтээгдэхүүн урьдчилсан байдлаар 776.3 тэрбум төгрөг болж, 2018 оны дүнгээс 12.6 хувиар, 2010 оны дүнгээс 96.4 хувиар, 2015 оны дүнгээс 35.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Аймгийн нэг хүнд 7.1 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн ногдож байна. 2019 оны дотоодын нийт бүтээгдэхүүнд аж үйлдвэрийн салбар 376.5 тэрбум.төг буюу 48.5 хувь, үйлчилгээний салбар 204.9 тэрбум.төг буюу 26.4 хувь, хөдөө аж ахуйн салбар 194.9 тэрбум.төг буюу 25.1 хувийг тус тус эзэлж байна.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн, салбараар, тэрбум төгрөгөөр****3.2 Мөнгө, банк**

Монгол банкны мэдээгээр Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнуудын зээлийн өрийн үлдэгдэл 2005 онд 9 861.3 сая, 2010 онд 47 690.4 сая төгрөг, 2015 онд 182 488.2 төгрөг, 2019 онд 301 744.8 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн байна. Иргэдийн мөнгөн хадгаламжийн хувьд 2005 онд 3 455.9 сая төгрөг, 2010 онд 18 121.3 сая төгрөг, 2015 онд 49 663.2 төгрөг, 2019 онд 105 667.5 сая төгрөг болж тус тус нэмэгдсэн байна.

**Иргэдийн мөнгөн хадгаламж, /тэрбум.төг/, Citizens' savings, /billion,mnt/****3.3 Төрийн сан, татвар**

2019 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн орлого 21 360.1 сая (93.5%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс аймгийн төсвийн орлого 15 638.6 сая (96.0%) төгрөгийн гүйцэтгэлтэй, сумдын төсвийн орлого 5 721.8 сая (117.0%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна. 2019 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр орон нутгийн төсвийн зарлага 91 623.7 сая (95.2%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага 41 356.7 сая (91.1%), Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлага 50 267.0 сая (98.8%) төгрөгийн гүйцэтгэлтэй байна.



Сумдад 13 737.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 43 810.8 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 2 484.8 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг тус тус шилжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн гүйцэтгэл 366.7 сая (85.5%) төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.




Татварын орлогын гүйцэтгэл 25 959.0 сая төгрөг болж төлөвлөгөөний биелэлт 107.7 хувьтай байна. Аймгийн хэмжээнд НӨАТ-ын урамшууллын системд хамрагдах боломжтой 1431 татвар төлөгч байгаагаас 559 (39.1%) НӨАТ-ын баримт олгож байна.



### 3.4 Гадаад худалдаа

Сэлэнгэ аймагт 2019 онд гадаад худалдааны нийт бараа эргэлт 313.0 сая америк доллар, үүнээс экспорт 6.0 сая америк доллар, импорт 307.0 сая америк доллар байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 18.0 (6.1%) сая америк доллар, үүнээс экспорт 0.03 (0.5%) сая америк доллар-аар буурч, импорт 18.1 (6.3%) сая америк доллар-аар өссөн байна.

#### Гадаад худалдааны бараа эргэлт, сая.\$



### 3.5 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 12 сард өмнөх сараас 0.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өссөн байна.


Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 11.5 хувь, хүнсний бараа согтууруулах бус ундаа 7.6 хувь, орон сууц ус цахилгаан хийн болон бусад түлш 5.2 хувь, гэр ахуйн тавилга гэр ахуйн бараа 1.2 хувь, согтууруулах



ундаа тамхи мансууруулах бодис 0.7 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 1.2 хувь, эм, тариа эмнэлгийн үйлчилгээ 0.2 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.4 хувиар өсөхөд хүнсний бараа согтууруулах бус ундаа 0.9 хувь, тээвэр 0.4 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 0.3 хувь, эм, тариа эмнэлгийн үйлчилгээ 0.1 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис 0.1 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үе), хувь



#### ХАА-н бүтээгдэхүүний үнэ.

Малын үнийг сүүлийн 10-н жилээр авч үзвэл бод малын дундаж үнэ 2010 онд 300.0 – 600.0 мянган төгрөг, бог малын хувьд 30.0 – 75.0 мянган төгрөг, 2012 онд бод мал 500.0 – 900.0 мянган төгрөг, бог мал 60.0 – 130.0 мянган төгрөг, 2016 онд бод мал 500.0 – 800.0 мянган төгрөг, бог мал 50.0 – 120.0 мянган төгрөг, 2019 онд бод мал 800.0 – 1 400.0 мянган төгрөг, бог мал 80.0 – 150.0 мянган төгрөгөөр тус тус худалдаалагдсан байна.

## 4. ЭДИЙН ЗАСГИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### 4.1 Бизнес регистрийн сан

Энэ оны байдлаар бизнес регистрийн санд 3 501 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 2 339 (66.8%) нь үйл ажиллагаа явуулж байна. Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 1 362 (58.2%) нь Сүхбаатар, Мандал, Ерөө суманд, 527 (22.5%) нь Сайхан, Хүдэр, Баянгол, Цагааннуур, Алтанбулаг суманд, 450 (19.3%) нь бусад сумдад үйл ажиллагаа явуулж байна.

Үйл ажиллагаа явуулаагүй 1 162 аж ахуйн нэгж, байгууллагын 575 (49.4%) нь үйл ажиллагаа эхлээгүй, 410 (35.3%) нь түр зогссон, 81 (7.1%) нь бүрэн зогсоосон, 96 (8.2%) нь хаяг тодорхойгүй болон бусад шалтгаантай байна.



### 4.2 Хөдөө аж ахуй

2019 онд аймгийн нийт малын тоо урьд оноос 142 453 (9.2%) толгойгоор өсч 1 682 489 толгой болж улсын дүнгийн 2.3 хувь, төвийн бүсийн 9.9 хувийг эзэлж байна. 2019 оны дүнгээр 1 хүнд 15.6 толгой мал ногдож байна. Малын тоог 1990 онтой харьцуулахад 3.2 дахин, 2000 онтой харьцуулахад 2.6 дахин, 2010 онтой харьцуулахад 416.9 (32.9%) мянган толгой, 2017 онтой харьцуулахад 172.5 (11.4%) мянган толгойгоор тус тус өссөн байна.



Малтай өрхийн тоо 2019 онд 9 554 болжээ. Үүнийг 1995 онтой харьцуулахад 2 257 өрхөөр, 2000 онтой харьцуулахад 900 өрхөөр тус тус буурсан байна. Харин 2015 оноос 148 өрхөөр өсч, өмнөх онтой харьцуулахад 60 өрхөөр өссөн байна. Малчин өрхийн тоо 2019 онд 4 856 болсон нь 2000 онтой харьцуулахад 2 053 өрхөөр, 2010 онтой харьцуулахад 669 өрхөөр, 2015 онтой харьцуулахад 663 өрхөөр, 2018 онтой харьцуулахад 6 өрхөөр тус тус өссөн байна.


2019 онд малчдын тоо 7 741 болсон нь 2005 оноос 1 034, 2010 оноос 729, 2015 оноос 310, өнгөрсөн оноос 357 малчнаар тус тус буурсан байна. 2019 оны мал тооллогын аймгийн дүнгээр 200 хүртэлх малтай 7 064 өрх, 201-999 хүртэлх малтай 2 290 өрх, 1 000 болон түүнээс дээш малтай 140 өрх тоологджээ.

2019 онд 100 эхээс бойжуулсан төл 85 болсон нь 2010 оноос 12 2011 оноос 2 толгойгоор тус тус бага, 1990 оноос 12, 2000 оноос 20, 2017 оноос 13, 2018 оноос 3 толгойгоор тус тус илүү, төл хүлээн авчээ.

608.6 мянган толгой төл бойжиж байгаа нь урьд оны мөн үетэй харьцуулахад 12.8 мянган (2.1%)-аар их байна.

2019 онд оны эхний нийт малын 0.44 хувьтай тэнцэх 6 725 толгой мал хорогдсон нь урьд онтой харьцуулахад 2.2 дахин буурчээ. Хорогдсон нийт малын 5.0 хувийг өвчнөөр хорогдсон, 28.1 хувь нь хээлтэгч малын хорогдол байна.

Үүнийг өмнөх онуудын мөн үетэй харьцуулахад 1990 оноос 12.0 (64.2%) мянган толгой, 1995 оныхоос 19.2 (74.1%) мянган толгой 2018 оныхоос 7.8 (54.0%) мянган толгойгоор тус тус буурсан байна.



Сэлэнгэ аймаг 2019 онд 153.4 мян.га- д үр тариа, 2.4 мян.га-д төмс, 2.7 мян.га- д хүнсний ногоо тус тус тариалсан нь улсын дүнгийн үр тарианы 41.5 хувь, төмсний 16.6 хувь, хүнсний ногооны 29.8 хувийг тариалжээ.


Харин төвийн бүсийн дүнгийн үр тарианы 64.6 хувь, төмсний 22.4 хувь, хүнсний ногооны 48.1 хувийг тариалсан байна.

2019 онд үр тариа 159 269.4 тн, төмс 34 104.9 тн, хүнсний ногоо 32 556.5 тонн хураан авсан нь улсын нийт үр тарианы 36.7 хувь, төмс 17.7 хувь, хүнсний ногоо 32.7 хувийг, харин төвийн бүсийн үр тарианы 60.2 хувь, төмс 23.1 хувь, хүнсний ногоо 52.4 хувийг тус тус хураан авсан байна. 2019 онд хураан авсан ургацыг 1990 онд хураан авсан ургацтай харьцуулахад үр тариа 32 729.5 тонн-р бага, харин төмс 2 804.5 тонноор, хүнсний ногоо 4.3 дахин их, 2000 онтой харьцуулахад үр тариа 82 261.9, төмс 25 175.1, хүнсний ногоо 23 632.0 тонноор тус бүр их, 2010 онтой харьцуулахад үр тариа 18 389.4, төмс 8 644.7 тонноор тус бүр бага, хүнсний ногоо 2 303.6 тонноор их ургац хураан авсан байна. Харин 2018 оны мөн үетэй харьцуулахад үр тариа 31.6 (16.6 %) мян.тн, хүнсний ногоо 2.1 (6.0%) мян.тн-р тус бүр бага, төмс өмнөх оны



мөн үетэй адил ургац хураан авсан байна. 2019 онд аймгийн хэмжээнд 116.4 мян.га-д уринш бэлтгэсэн байна.

Хураан авсан ургац /мян.тн/, Harvested harvest /thousand tons/




#### 4.3 Аж үйлдвэр

2019 оны жилийн эцсийн байдлаар аж үйлдвэрийн салбарт 462.2 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 515.1 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь урьд оны мөн үеэс үйлдвэрлэлт 85.1 (22.6%) тэрбум төгрөгөөр, борлуулалт 124.4 (31.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 289.6 (62.7%) тэрбум төгрөг нь уул уурхайн салбарт, 162.6 (35.2%) тэрбум төгрөг нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 10.0 (2.1%) тэрбум төгрөг нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт салбарт бүтээгджээ. 2019 оны байдлаар аж үйлдвэрийн салбарт нийт 2 891 ажиллагсад ажиллаж байна. Үүний 24.0 хувь буюу 694 нь эмэгтэйчүүд эзэлж байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт, сая.төг



#### 4.4 Барилга

2019 онд Сэлэнгэ аймагт 41 790.3 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 28 573.7 сая төгрөг буюу 3.2 дахин өссөн байна.



Нийт барилга угсралт их засварын ажлын 5.1 хувийг орон сууцны барилга, 20.3 хувийг орон сууцны бус барилга, 67.3 хувийг инженерийн барилга байгууламж, 7.3 хувийг их засварын ажил эзэлж байна.



#### 4.5 Тээвэр

Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 17 578 тээврийн хэрэгсэл үзлэгт хамрагдсан нь өнгөрсөн оны мөн үеэс 747 (4.4%) өссөн байна. 2 838 тээврийн хэрэгсэл эзэмшигчийн шилжилт хөдөлгөөн хийж, 114 тээврийн хэрэгслийн хасалт хийсэн байна. Мөн импортоор орж ирсэн 123 мотоциклд шинээр улсын дугаар, гэрчилгээ олгосон байна. Аймгийн тээврийн салбар нь 2019 онд 98 мянган тн ачааг 85.6 мян.км зам туулан тээвэрлэлт хийсэн байна. Тус салбар нь 2019 онд 290.2 мянган хүн тээвэрлэсэн нь өмнөх оноос 51.5 хувиар буурч, зорчигч эргэлт 21 554.9 мян.хүн.км болж 37.7 хувиар буурсан байна. Тээврийн салбарын нийт орлого 2019 онд 1 117.7 сая төгрөгт хүрч өмнөх оноос 38.3 хувиар буурсан байна. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машины тоо 2019 онд 16 315 болсон нь өмнөх оноос 5 096 (45.4%) машинаар өссөн байна.

## 5. БАЙГАЛЬ ОРЧНЫ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ



### 5.1 Цаг уур орчны мэдээ

#### ТАНЫ АНХААРАЛД

Цаг агаарын сарын урьдчилсан мэдээнд тухайн сард агаарын дундаж температур болон орох хур тунадасны хэмжээ нь олон жилийн дундажтай харьцуулахад ямар байхыг баруун (Баян-Өлгий, Ховд, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор), төв (Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Төв, Орхон, Дархан-Уул), зүүн (Хэнтий, Дорнод, Сүхбаатар), говийн (Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Сүмбэр) нутгийн гэсэн **4 бүс** нутаг тус бүрээр ялган зааж өгдөг. Түүнчлэн хэдий үед нутгийн аль хэсэгт дулаарах, хүйтрэх, бороо, цас орох, салхи шуурга болохыг тусгана. Цаг агаарын үзэгдэл нутгийн **30 хувиас** хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд “зарим газраар”, **30-70 хувьд** “ихэнх нутгаар”, **70 хувиас дээш** нутгийг хамрах тохиолдолд “бүх нутгаар” гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур **00-ээс** бага болж хүйтрэхийг “цочир хүйтрэл” гэнэ.

Цаг агаарын урьдчилсан мэдээг өдөр бүр 12 цагаар болон нэг, тав хоногоор нарийвчлан гаргаж радио, телевиз, хэвлэлээр нийтэд мэдээлдэг. Цаг агаарын байдал эрс өөрчлөгдөн цаашид хөдөө аж ахуйн болон эдийн засгийн бусад салбарын хэвийн үйл ажиллагаанд саад хийхээр аюултай үзэгдлийн хэмжээнд хүрч болзошгүй тохиолдолд “Урьдчилан анхааруулах мэдээ”, “Урьдчилан сэрэмжлүүлэх мэдээ” гаргаж радио, телевизээр нийт ард иргэдэд, харин ноцтой бэрхшээл учруулж эд хөрөнгө, иргэдийн амь нас хохирохоор онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрэхээр бол “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ” гаргаж “Харанга” дохиотойгоор мэдээлэх ба мэдээллийг онцгой байдлын шугамаар нийт ард иргэд, төр засгийн бүх шатны удирдлагад яаралтай хүргэдэг. Засаг дарга нар “Гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ”-г хүлээн авмагц мэдээллийг өөрийн харьяа нутаг дэвсгэрийн иргэдэд хүргэх, гамшгаас хамгаалах, гамшгийн голомтод ажиллах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах үүрэгтэй.

Ус, цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас хүний амь нас эрсдсэн, байгаль орчин, эд хөрөнгөнд хохирол учирсан тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга ажлын хэсэг томилон



ажиллуулж, уг гамшигт үзэгдлээс хамгаалах талаар зохион байгуулсан арга хэмжээ, үр дүн, учирсан хохирол, гарсан зардлын талаарх мэдээллийг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой байдлын газар, хэлтэс, Улсын онцгой байдлын ерөнхий газарт, аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв Ус цаг уурын хүрээлэнд 3 хоногийн дотор тус тус ирүүлнэ.

Цаг агаарын мэдээний талаар лавлах, эсвэл байгаль цаг уурын сонин хачин үзэгдлийн талаарх мэдээллийг Улаанбаатар хотын 326606, **326609** утсаар өгөх юмуу “УБ-46, Жуулчны гудамж-5, Ус цаг уурын хүрээлэнгийн “Урьдчилан мэдээлэх сектор” гэсэн хаягаар ирүүлнэ.

### **Уур амьсгалын тойм** *Climate review*

Нэгдүгээр сарын агаарын температурын уур амьсгалын дундаж нь **22-27** градус хүйтэн байдаг боловч сүүлийн 20 гаруй жилийн байдлаар 1981, 1984, 2000, 2005, 2008, 2010, 2011, 2016 онуудад уур амьсгалын дунджаас **2-10** градусаар хүйтэн болж, шөнийн үнэмлэхүй бага температур 38-44 градус хүрч хүйтэрсэн бол 1982, 1985, 1986, 1989, 1992, 1994, 1999, 2002, 2006, 2007, 2015 онуудад уур амьсгалын дунджаас **1-7** градусаар дулаан байж, өдөртөө 1 градус хүйтнээс 5 градус хүрч дулаарч байжээ.

Энэ сард уур амьсгалын дунджаар Сэлэнгэ аймгийн нутгаар **2-4** мм цас ордог боловч 1980, 1982, 1993, 1995, 1999, 2006 онуудад тун бага цас орсон бол 1987, 2002, 2001, 2003, 2005, 2007, 2010, 2011 онуудад уур амьсгалын дунджаас 1-4 дахин их цас оржээ. Уур амьсгалын дундаж байдлаар **10-15 см** зузаан цас тогтдог боловч цас их орсон жилүүдэд цасны дундаж зузаан 40-60 см-т хүрч мал өвөлжилтийн байдал онцгой хүндэрч байжээ.

Салхи 15 м/с-ээс хүчтэй болох тохиолдол жил бүр **1-3** удаа ажиглагддаг.

### **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ** *Weather forecast*

Агаарын температур нь Сэлэнгэ аймгийн нутгаар уур амьсгалын дунджаас хүйтэн байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхээр хүйтний эрч бага зэрэг суларч шөнөдөө 25-30 градус, өдөртөө 14-19 градус хүйтэн байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд үеэс хүйтний эрч чангарч шөнөдөө 37-42 градус, өдөртөө 25-30 градус хүйтэн байна. Бусад хугацаанд шөнөдөө 28-33 градус, өдөртөө 17-22 градус хүйтэн байна.

Энэ сард орох цасны хэмжээ нь Сэлэнгэ аймгийн нутгаар олон жилийн дунджаас ахиу байх төлөвтэй.

Нэг дүгээр арав хоногийн сүүлчээр нутгийн зарим газраар, хоёр болон гуравдугаар арав хоногийн дунд үер ихэнх нутгаар цас орж, цасан шуурга шуурна. Энэ үеэр салхи зарим газраар 12-14 м/с, зарим үед зарим газраар түр зуур 16-18 м/с хүртэл ширүүсэх төлөвтэй.

#### **урьдчилсан мэдээ**

#### **5.2 Ойжуулалт, тарьц, нөхөн сэргээлтийн мэдээ**

Аймгийн хэмжээнд 17 сумын 60 гаруй иргэн, нөхөрлөл, аж ахуй нэгж, байгууллага мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр мод үржүүлгийн газрууд 20 гаруй төрлийн 12.0 сая ширхэг тарьц, суулгац бойжуулан ургуулж байна. 2019 онд нийт 161.4 га талбайд нөхөн сэргээлт хийснээс 101.7 га талбайд техникийн, 60.2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна. Үүнээс: БОАЖНХСайдын 2015 оны А/419 тушаалын дагуу 6 аж ахуй нэгж байгууллагын нийт 46.9 га техник, 36.15 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. 2019 онд Хүдэр, Ерөө сумдад 33.4 га талбайд дүйцүүлэн



хамгаалах ажлыг “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Болдтөмөр Ерөө Гол” ХХК “Бугант нандин” ХХК –ууд хийж гүйцэтгэсэн байна.

### **5.3. Агаар, усны бохирдлын мэдээ**

Сэлэнгэ аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албаны Байгаль орчны шинжилгээний лабораторийн 2019 оны 4-р улиралд Орхон голын дунд, эцсийн цэг, Сэлэнгэ - 12 зөрлөгөөс авсан дээжинд хийсэн шинжилгээний дүнгээс үзэхэд гадаргын усны MNS 4586;98 стандартын дагуу байна. Агаарын чанарын Сүхбаатар харуулын орчимд хийсэн шинжилгээний дүн агаарын чанарын стандартын дагуу байгаа боловч галлагаатай үеийн явуул судалгаагаар Вокзал, Салхитын ам, 60-н айлын орчимд азотын давхар исэл 0.155 мг\м<sup>3</sup>, хүхэрлэг хий 0.010 мг\м<sup>3</sup> байна. Нийт тоосны агууламж 0.538 – 0.729 мг\м<sup>3</sup> буюу стандартаас 1.08 – 1.46 дахин давж бохирдсон байна.

## **6. БУСАД**

### **а. Хяналт шалгалт**

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар 2019 оны жилийн эцсийн байдлаар 1 529 аж ахуйн нэгж байгууллага, 310 иргэнд хяналт, шалгалт хийж, 3 481 зөрчил дутагдал илрүүлж, 1 751 зөрчил арилгуулсан байна.

2019 онд Санхүү хяналт, аудитын алба нийт 73 аж ахуй нэгж байгууллагад хяналт, шалгалт хийж 8990.1 мянган төгрөгийн төлбөр бүхий зөрчил илрүүлж, 282 аж ахуй нэгж, байгууллагад зөвлөмж өгч ажилласан байна.

2019 онд аймгийн Төрийн аудитын газар гүйцэтгэлийн аудитын 48 аж ахуй нэгж байгууллагад, нийцлийн аудитын 445 аж ахуйн нэгж байгууллагад, санхүү аудитыг 294 аж ахуй нэгж байгууллагад хийж нийт 355 зөрчил илрүүлсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар энэ онд 643 аж ахуйн нэгж байгууллага, 146 иргэнд хяналт, шалгалт хийж, 1 815 зөрчил дутагдал илрүүлж, 620 зөрчил арилгуулсан байна.

### **б. Онцгой байдлын газрын мэдээ**

Сэлэнгэ аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар 613 объект, 2 175 айл өрх үзлэг шалгалтад хамрагдаж, 3 234 зөрчил илрүүлсэн, 800 зөрчил дутагдлыг арилгуулсан байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар объектод 132, ой хээрийн 16 гал түймэр гарч 471.9 сая төгрөгийн хохирол учирсан байна.

### **с. Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Шүүх шинжилгээний алба**

Сум дундын шүүхийн мэдээгээр энэ онд 947 хэрэг шийдвэрлэснээс 202 (21.3%) нь эрүүгийн хэрэг, 701 (74.0%) нь иргэний хэрэг, 44 (4.7%) нь захиргааны хэрэг байна. Он гараад бүгд 173 хүн ял шийтгүүлж, 53 хүн хорих ял шийтгүүлсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд оны эхний үлдэгдэл 395 гүйцэтгэлийн материал байсан бөгөөд энэ онд 561 материал нэмэгдэж, 94 материал хасагдсан бүгд 862 гүйцэтгэлийн материалаар 6 632.5 сая төгрөгийн өрийг барагдуулахаас 487 гүйцэтгэлийн материалаар 2 886.3 сая төгрөгийн өрийг бодитой барагдуулжээ.

2019 онд ШША-ны криминалистик шинжээч нар бүгд 98 шинжилгээ хийж, 493 хэргийн газарт үзлэг хийхэд оролцсон байна. Шүүхийн шинжилгээний эмнэлэг нь энэ онд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 528, цогцост шинжилгээ 173, эксгумаци хавтаст хэргийн материалаар хийсэн шинжилгээ 5, хүний биед хийсэн бусад үзлэг 47 байна.

**d. Стандарт хэмжил зүйн хэлтэс**

2019 оны жилийн эцсийн байдлаар 4 486 хэмжих хэрэгсэл баталгаажуулснаас механик 770, цахилгаан 2918, эзлэхүүн багтаамж 588, дулаан даралт 210 хэмжих хэрэгсэл байна. Тохирлын гэрчилгээ олгосон бүтээгдэхүүн 7, үйлчилгээний тохирлын гэрчилгээ 280 байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 4 итгэмжлэгдсэн лабораториор 196 иргэд, аж ахуйн нэгж стандартын салбар сангаар үйлчлүүлсэн байна.

**e. Улсын бүртгэлийн хэлтэс**

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээгээр төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийн баталгаажуулалтыг 19 иргэн, газраас бусад ҮХЭХЭ-н анхны бүртгэл, баталгаажуулалтыг 439 иргэн баталгаажуулж 3 гэмтээсэн гэрчилгээг, 17 үрэгдүүлсэн гэрчилгээг тус тус шинээр олгож, 411 иргэн лавлагаа, хуулбар хийлгэж, нийт 1 522 гэрчилгээ бичигдсэн байна. Мөн Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн мэдээгээр 7 161 мэдүүлэг хүлээн авч, төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг 1 805 иргэн баталгаажуулсан байна. Өмчлөх эрх шилжих гэрээ 891 хийгдсэнээс худалдах, худалдан авах гэрээ 519, бэлэглэх гэрээ 159, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөх гэрээ 97 хийгдэж, 23 үрэгдүүлсэн гэрчилгээг шинээр олгож нийт 2 838 гэрчилгээ бичигдсэн байна. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны байдлаар нийт үйлчилгээний хураамж 173.5 сая төгрөг, ҮХЭХЭ-ээ худалдсанаас оруулсан татварын орлого 159.9 сая төгрөг төвлөрсөн байна.

**f. Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар**

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэдээгээр Газар өмчлөх тухай өргөдөл 2 216 иргэн гаргаснаас 2 090 иргэнд газар өмчлүүлсэн байна. Үүнээс Улсын чанартай зам дагуу газрыг 775 иргэнд, шинээр газар өмчлүүлсэн нь 1270 иргэнд, одоо эзэмшиж байгаа газраа өмчлүүлсэн 45 иргэн байна. МУ-ын Засгийн газар, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор тус тус 2019 онд Сэлэнгэ аймгийн хэмжээнд нийт 236.52 га газрыг өмчлүүлсэн байна.

**g. Түүвэр судалгаа**

2019 онд Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтэс Үндэсний статистикийн хорооны нэгдсэн арга зүйн дагуу Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааг 408 өрхөөс, Ажиллах хүчний судалгааг 660 өрхөөс авч, судалгаанд хамрагдсан өрхүүдэд урамшуулал болгон 4 020.0 мянган төгрөг олгосон байна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ГҮНДЭГМАА



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жилийн эцсийн байдлаар

## 1. ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР

## 1.1 НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

## TERRITORIAL AND ADMINISTRATIVE UNITS

Сумын нэр	Soum	Багийн тоо /Bags/	Нутаг дэвсгэрийн хэмжээ, км <sup>2</sup> /Territory/	Хүн амын нягтшил /Population density/	Сүхбаатар сумаас хүрэх урт км-ээр /Distance between soum centers and aimag, kilometers/
<b>ДҮН</b>		<b>57</b>	<b>41 152.6</b>	<b>2.6</b>	<b>-</b>
<b>1. Бэлчирийн бүс</b>	<b>Belchir region</b>				
А.Сүхбаатар	Sb	8	45.4	502.8	-
Б.Алтанбулаг	Ab	3	2 100.3	2.3	25
В.Шаамар	Shr	3	671.9	6.0	21
<b>2.Ерөөгийн бүс</b>	<b>Yeruu region</b>				
А.Ерөө	Yer	3	8 203.5	0.8	90
Б.Хүдэр	Khr	2	2 838.7	0.9	167
В.Жавхлант	Ja	2	1 189.7	1.6	79
<b>3.Хараагийн бүс</b>	<b>Kharaa region</b>				
А.Мандал	Ma	9	4 843.7	5.6	220
Б.Баянгол	Bg	3	1 976.3	2.8	175
<b>4.Орхоны бүс</b>	<b>Orkhon region</b>				
А. Сайхан	Sn	4	1 311.9	7.1	160
Б.Сант	Sa	2	1387	1.5	200
В.Орхон	Or	2	1 306.3	1.8	161
Г.Орхонтуул	Ot	3	2 940.8	1.3	260
Д.Баруунбүрэн	Bb	3	2 814.5	1.1	220
Е.Хушаат	Khu	2	2 010.2	1.0	100
<b>5.Сэлэнгийн бүс</b>	<b>Selenge region</b>				
А.Зүүнбүрэн	Zb	3	1 204.9	2.4	48
Б.Цагааннуур	TSn	3	3 814.7	1.3	87
В.Түшиг	Tu	2	2 492.8	0.7	129

**2. ХҮН АМ, НИЙГМИЙН СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ****2.1.1. СЭЛЭНГЭ АЙМАГТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, сумаар**  
RESIDENT POPULATION OF SELENGE AIMAG, soum

Сумын нэр	Soum	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>88 927</b>	<b>93 270</b>	<b>94 807</b>	<b>90 190</b>	<b>101 752</b>	<b>104 725</b>	<b>106 677</b>	<b>108 768</b>	<b>109 255</b>	<b>107 755</b>
Алтанбулаг	Ab	3 714	2 853	3 512	4 043	5 051	4 729	5 052	5 089	5 008	4 750
Баруунбүрэн	Bb	2 608	2 969	2 935	2 109	2 850	3 111	3 197	3 184	3 162	3 094
Баянгол	Bg	5 306	5 287	5 444	4 395	5 497	5 403	5 516	5 608	5 579	5 567
Ерөө	Yer	6 289	5 888	5 766	5 209	6 374	6 393	6 494	6 752	6 856	6 834
Жавхлант	Ja	1 510	1 655	1 652	1 594	1 910	1 974	2 099	2 164	1 962	1 970
Зүүнбүрэн	Zb	2 549	2 496	2 524	2 162	2 665	2 704	2 756	2 832	2 865	2 819
Мандал	Ma	18 617	22 506	22 043	22 937	25 009	26 600	26 880	27 162	27 241	27 011
Орхон	Or	2 881	2 591	2 591	2 081	2 298	2 306	2 369	2 376	2 377	2 290
Орхонтуул	Ot	3 650	3 571	3 918	3 274	3 617	3 621	3 680	3 778	3 788	3 754
Сайхан	Sn	2 414	8 008	8 690	8 084	8 809	9 130	9 325	9 375	9 418	9 302
Сант	Sa	2 721	2 103	2 050	2 018	2 225	1 961	2 094	2 169	2 143	2 104
Сүхбаатар	Sb	25 346	20 057	20 513	19 247	22 065	22 238	22 482	22 911	23 151	22 578
Түшиг	Tu	1 709	1 839	1 787	1 594	1 476	1 694	1 739	2 004	1 848	1 835
Хушаат	Khu	1 060	1 136	1 233	1 698	1 754	1 831	1 929	1 989	2 065	2 067
Хүдэр	Khr	2 068	2 070	1 529	1 907	2 119	2 384	2 424	2 490	2 651	2 706
Цагааннуур	TSn	2 903	3 242	4 163	4 078	4 065	4 687	4 783	5 011	5 077	5 081
Шаамар	Shr	3 582	4 999	4 457	3 760	3 968	3 959	3 858	3 874	4 064	3 993



**2.1.2. СЭЛЭНГЭ АЙМАГТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, насны бүлэг**  
RESIDENT POPULATION OF SELENGE AIMAG, by age group

Насны бүлэг Age group	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд / Total	96 096	97 460	101 763	101 411	105 253	104 725	106 677	108 768	109 255	107 755
0-4	8 810	9 325	10 468	10 550	11 077	12 101	11 812	11 926	12 242	11 889
5-9	7 844	7 832	8 234	8 671	9 456	10 325	10 995	11 422	11 508	11 529
10-14	8 821	8 614	8 783	8 345	8 045	7 964	8 039	8 309	8 769	9 366
15-19	10 198	9 634	9 273	9 040	8 877	8 542	8 468	8 625	8 341	7 915
20-24	10 878	11 027	11 387	10 631	10 239	9 048	8 541	8 415	8 312	7 994
25-29	8 662	8 747	9 286	9 478	9 897	9 621	9 900	9 874	9 229	8 252
30-34	8 000	7 995	8 034	7 972	8 478	8 118	8 405	8 603	8 732	8 570
35-39	7 305	7 575	7 612	7 564	7 856	7 742	7 912	7 940	7 793	7 683
40-44	6 805	6 839	7 150	7 013	7 494	7 293	7 561	7 591	7 506	7 304
45-49	6 001	6 345	6 577	6 625	6 833	6 768	6 843	7 009	6 963	7 024
50-54	4 637	4 832	5 442	5 645	6 168	5 982	6 378	6 397	6 477	6 298
55-59	2 860	3 270	3 549	3 847	4 300	4 642	4 743	5 092	5 350	5 507
60-64	1 877	1 917	2 217	2 308	2 622	2 661	3 046	3 223	3 533	3 715
65-69	1 311	1 386	1 418	1 393	1 449	1 595	1 623	1 852	1 949	2 108
70+	2 087	2 122	2 333	2 329	2 462	2 323	2 411	2 490	2 551	2 601

**2.1.3. СЭЛЭНГЭ АЙМАГТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, хүйсээр**  
RESIDENT POPULATION OF SELENGE AIMAG, by gender

Үзүүлэлт	Indicator	1990	1995	2000	2005	2010	2015	2016	2017	2018	2019*
Бүгд	Total	88 927	93 270	99 833	94 369	96 096	104 725	106 677	108 768	109 255	107 755
Эрэгтэй	Male	44 082	46 278	49 790	46 692	47 758	53 165	53 942	55 067	55 328	54 706
Эмэгтэй	Female	44 845	46 992	50 043	47 677	48 338	51 560	52 735	53 701	53 927	53 049



**2.1.4. СЭЛЭНГЭ АЙМАГТ ОРШИН СУУГАА ХҮН АМЫН ТОО, сумаар, насны бүлэг**  
**RESIDENT POPULATION OF SELENGE AIMAG, by soum, age group, 2019\* year**

Сумын нэр	Soum	Насны бүлэг / Age group																			
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70-74	75-79	80-84	85-89	90-94	95+
Алтанбулаг	Ab	504	517	429	372	1 443	327	373	311	353	336	302	233	165	85	46	33	12	3	1	2
Баруунбүрэн	Bb	386	343	291	261	346	235	221	214	192	197	144	146	87	61	28	24	10	3	5	0
Баянгол	Bg	600	594	467	415	246	438	420	424	369	351	323	289	210	104	53	46	18	8	4	1
Ерөө	Yer	794	744	587	480	433	541	618	502	471	411	374	320	231	129	56	41	21	10	2	2
Жавхлант	Ja	220	199	180	132	500	139	152	157	130	120	118	102	71	52	18	20	3	2	0	0
Зүүнбүрэн	Zb	343	316	255	192	155	195	207	211	205	169	162	115	100	59	36	19	16	5	0	1
Мандал	Ma	2 912	2 802	2 389	1 921	213	2 097	2 232	1 999	1 823	1 738	1 530	1 337	960	536	284	216	132	44	17	2
Орхон	Or	225	224	178	207	2 040	171	158	142	188	141	126	138	82	46	32	29	10	2	1	1
Орхонтуул	Ot	373	361	339	336	189	272	267	275	256	263	257	183	125	62	32	24	18	6	1	0
Сайхан	Sn	986	973	799	656	304	801	734	641	608	617	627	548	247	136	83	53	30	15	3	1
Сант	Sa	222	201	189	168	744	152	130	137	137	148	129	124	100	44	17	9	9	3	3	0
Сүхбаатар	Sb	2 420	2 473	1 877	1 594	182	1 642	1 896	1 600	1 533	1 539	1 315	1 224	871	514	280	196	106	41	13	1
Түшиг	Tu	210	218	162	123	132	136	155	122	120	122	110	95	63	29	18	14	5	1	0	0
Хүдэр	Khu	333	311	209	204	201	214	206	169	179	167	175	126	98	61	24	14	9	4	2	0
Хушаат	Khr	238	241	197	166	162	124	142	173	154	147	99	91	52	36	21	16	6	2	0	0
Цагааннуур	TSn	641	613	477	387	422	432	382	339	337	304	252	223	119	70	37	25	11	5	4	1
Шаамар	Shr	482	399	341	301	282	336	277	267	249	254	255	213	134	84	56	39	17	6	1	0
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>11 889</b>	<b>11 529</b>	<b>9 366</b>	<b>7 915</b>	<b>7 994</b>	<b>8 252</b>	<b>8 570</b>	<b>7 683</b>	<b>7 304</b>	<b>7 024</b>	<b>6 298</b>	<b>5 507</b>	<b>3 715</b>	<b>2 108</b>	<b>1 121</b>	<b>818</b>	<b>433</b>	<b>160</b>	<b>57</b>	<b>12</b>

**2.1.5. ШИЛЖИЖ ИРСЭН ИРГЭДИЙН ТОО, сумдаар**  
IN MIGRATION CITIZEN, soum

Сумын нэр	Soum	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>3 639</b>	<b>2 242</b>	<b>1 789</b>	<b>1 690</b>	<b>1 430</b>	<b>1 398</b>	<b>1 639</b>	<b>1 563</b>	<b>1 323</b>	<b>2 777</b>
Алтанбулаг	Ab	259	135	63	82	63	68	74	73	18	40
Ерөө	Yer	131	127	106	66	69	53	76	110	62	154
Зүүнбүрэн	Zb	67	32	92	36	30	31	35	41	37	64
Мандал	Ma	709	536	372	319	295	302	351	302	480	894
Орхон	Or	94	36	40	29	34	26	37	26	16	39
Сант	Sa	83	52	33	39	29	29	32	51	24	111
Цагааннуур	TSn	103	92	51	44	30	43	51	55	38	113
Баянгол	Bg	193	99	81	102	67	94	89	98	62	233
Сайхан	Sn	375	197	162	221	199	149	190	168	179	411
Орхонтуул	Ot	143	144	40	79	50	50	51	60	34	57
Баруунбүрэн	Bb	74	27	82	53	57	50	36	50	41	112
Шаамар	Shr	115	51	48	50	45	54	52	65	39	96
Хүдэр	Khr	26	42	49	43	29	42	39	41	32	61
Сүхбаатар	Sb	1 107	558	500	425	333	307	401	332	190	248
Жавхлант	Ja	39	48	24	44	55	38	50	42	15	49
Түшиг	Tu	39	33	17	20	20	29	37	15	17	40
Хушаат	Khu	82	33	29	38	25	33	38	34	39	55

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтэс

**2.1.6. ШИЛЖИЖ ЯВСАН ИРГЭДИЙН ТОО, сумдаар**  
OUT MIGRATION CITIZEN, soum

Сумдын нэр	Soum	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
<b>Бүгд</b>	<b>Total</b>	<b>3 155</b>	<b>3 174</b>	<b>2 730</b>	<b>2 600</b>	<b>3 548</b>	<b>3 129</b>	<b>2 942</b>	<b>2 370</b>	<b>1 383</b>	<b>1 324</b>
Алтанбулаг	Ab	147	204	144	168	175	160	174	117	62	18
Ерөө	Yer	154	124	128	144	152	135	121	111	83	56
